

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чойр-Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт 220.4 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35 кВ-ын дэд станц барих төсөл 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/81/НА-СТА-ТХН

Цахим www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	хуудас:	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер Б.Долгорсүрэн Утас: 260512 Цахим хаяг: dolgorsuren.b@audit.gov.mn Аудитор П.Амарсанаа Утас: 261628 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн захирал С.Тунгалаг Утас:70001778 Цахим хаяг: info@imkaudit.mn
---------------------------------------------------------------------------------------	---------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	12
3.5.2.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	13
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Зөвлөмж	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТҮ	Төрийн үйлчилгээ
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН
НЭГДСЭН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
НЭГЖИЙН ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Н.УУГАНЧИМЭГ

2026.04.03 № 06/940
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чойр-Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт 220.4 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35 кВ-ын дэд станц барих төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Чойр-Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт 220.4 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35 кВ-ын дэд станц барих төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 17,388.0 мянган төгрөгөөс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Төслийг хэрэгжүүлэхээр Европын сэргээн болголт, хөгжлийн банктай 2019 оны 04 сарын 09-ны өдөр байгуулсан 62,800.0 мянган ам долларын зээлийн хэлэлцээрт, уг төслийг 2026 оны 12 сарын 31-ны өдөр дуусгахаар төлөвлөсөн боловч тайлант онд 960.0 мянган ам долларын зөвлөх үйлчилгээний гэрээний урьдчилгаа төлбөрт 227.5 мянган ам доллар буюу 813,597.9 мянган төгрөгийг шилжүүлж, барилга угсралтын ажил хийгдэж эхлээгүй байна.
- Зээллэгийн хөрөнгийг бүрэн ашиглаагүйгээс дамжуулан зээлдүүлэх гэрээний нөхцөлийн дагуу 2 дугаар эх үүсвэрээс 31.0 мянган ам доллар буюу 110,256.5 мянган төгрөгийн хураамж төлж үргүй зардал гаргах эрсдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай,

хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Сангийн сайдын 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалын хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.1.2-т "Төсөл, арга хэмжээг тогтоосон хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлэх" 4.1.3-т "Санхүү, төсвийн зохистой, үр ашигтай удирдлагыг хэрэгжүүлэх", 4.1.5-д "Үйл ажиллагааны шуурхай, хариуцлагатай, тогтвортой байдлыг хангах", Зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 139/г-36/2023/203/205 дугаар гэрээний гэрээний 1.1.4-д "Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж нь жилийн 0.5 хувь байх ба зээлийн гэрээ байгуулагдсан өдрөөс эхлэн тухайн ашиглаж буй эх үүсвэрээр тооцно. Нэгдүгээр эх үүсвэр ашиглагдаж дууссанаар хоёрдугаар эх үүсвэрийн ашиглаагүй үлдэгдлээс тооцно" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Барилга угсралтын ажлын үнэлгээний хороог 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/158 тоот тушаалаар байгуулж урьдчилсан шалгаруулалтыг 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан. Үүний дараа тендерийг 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдөр нээсэн бөгөөд Үнэлгээний хорооны ажлын тайлан, шийдвэрт банкнаас 2026 оны 02 дугаар сарын 05-ны өдөр урьдчилсан байдлаар "үл татгалзал"-ыг өгсөн тул албажуулах хүсэлтийг хүргүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Зөвлөх үйлчилгээний ажлыг 2024 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 23120304 тоот гэрээг "Joint Venture GREEN-Energotranspoeckt-PCDP-NBT" компанитай байгуулж гэрээний урьдчилгаа 227.5 мянган ам.доллар шилжүүлсэн байна.

Бусад асуудал

Төсөл хариуцагч нэгжийн хяналт шинжилгээ үнэлгээний ажилтан тайлант оны төлөвлөсөн төлөвлөгөөний гүйцэтгэлийг 92.5 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	14,680,637.56	800,000.00
33	АВЛАГА	11,730,637.56	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	10,805,345.13	-
33500	Бусад авлага	925,292.43	-
33510	Байгууллагаас авах авлага	925,292.43	-
35	БАРАА МАТЕРИАЛ	2,950,000.00	800,000.00
35400	Хангамжийн материал	2,950,000.00	800,000.00
35410	Бичиг хэргийн материал	2,150,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	800,000.00	800,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	78,697,449.85	46,764,649.69
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	78,697,449.85	46,764,649.69
39200	Биет хөрөнгө	77,232,249.89	45,462,249.77
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	51,972,000.00	51,972,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(22,297,000.00)	(44,583,000.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,840,000.00	44,840,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,282,750.07)	(6,766,750.23)
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,000,000.00	10,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,000,000.04)	(10,000,000.00)
39300	Биет бус хөрөнгө	1,465,199.96	1,302,399.92
39301	Програм хангамж	1,628,000.00	1,628,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(162,800.04)	(325,600.08)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	93,378,087.41	47,564,649.69
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,385,762.52	2,907,337.05
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,385,762.52	2,907,337.05
41300	Өглөг	4,385,762.52	2,907,337.05
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	4,385,762.52	-
41360	Бусад өглөг	-	2,907,337.05
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	-	2,907,337.05
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	88,992,324.89	44,657,312.64
51	Засгийн газрын хувь оролцоо	88,992,324.89	44,657,312.64
51200	Хуримтлагдсан үр дүн	88,992,324.89	44,657,312.64
51210	Өмнөх үеийн үр дүн	57,694,102.55	88,992,324.89
51220	Тайлант үеийн үр дүн	31,298,222.34	(44,335,012.25)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	93,378,087.41	47,564,649.69

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	819,065,000.00	802,817,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	802,817,300.00
122	Тусламжийн орлого	-	802,817,300.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	802,817,300.00
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	802,817,300.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	802,817,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	819,065,000.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	819,065,000.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	819,065,000.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	787,766,777.66	1,660,750,181.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	787,766,777.66	1,660,750,181.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	564,373,327.36	1,623,389,555.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	411,329,089.00	590,349,132.00
210101	Үндсэн цалин	411,329,089.00	590,349,132.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,605,136.14	77,626,289.24
210201	Тэтгэврийн даатгалын зардал	34,962,972.57	54,011,426.12
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	4,113,290.89	5,903,490.78
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	3,245,645.45	2,951,895.39
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	2,056,645.45	2,951,895.39
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	8,226,581.78	11,807,581.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,172,000.00	74,117,658.33
210304	Байрны түрээс	54,172,000.00	74,117,658.33
2104	Хангамж, бараа материалын зардал	13,452,850.00	7,895,847.51
210401	Бичиг хэрэг	5,327,500.00	5,288,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,700,000.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,136,850.00	2,107,847.51
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,288,500.00	-
2107	Томилолт, зочны зардал	5,830,802.07	26,690,345.13
210702	Дотоод албан томилолт	3,830,802.07	26,690,345.13
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	940,900.00	813,597,868.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	813,597,868.80
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	640,900.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,042,550.15	33,112,414.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,179,614.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,042,550.15	31,932,800.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	223,393,450.30	37,360,625.88
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	37,360,625.88
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	37,360,625.88
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	37,360,625.88
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	37,360,625.88
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	223,393,450.30	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	223,393,450.30	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	31,298,222.34	(857,932,881.05)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	813,597,868.80
145005	Дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх	-	813,597,868.80
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-	813,597,868.80
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	31,298,222.34	(44,335,012.25)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	819,065,000.00	802,817,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	802,817,300.00
122	Тусламжийн орлого	-	802,817,300.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	802,817,300.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	802,817,300.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	802,817,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	819,065,000.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	819,065,000.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	819,065,000.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	764,399,000.00	1,616,415,168.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	764,399,000.00	1,616,415,168.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	541,005,549.70	1,579,054,542.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	407,443,045.94	594,734,912.52
210101	Үндсэн цалин	407,443,045.94	594,734,912.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,122,753.76	73,793,641.76
210201	Тэтгэврийн даатгалын зардал	36,123,490.52	50,178,778.64
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	4,249,820.81	5,903,490.78
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	2,992,840.25	2,951,895.39
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	1,256,960.56	2,951,895.39
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	8,499,641.62	11,807,581.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,172,000.00	74,117,658.33
210304	Байрны түрээс	54,172,000.00	74,117,658.33
2104	Хангамж, бараа материалын зардал	13,036,850.00	5,745,847.51
210401	Бичиг хэрэг	5,280,200.00	3,138,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,831,300.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,136,850.00	2,107,847.51
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,788,500.00	-
2107	Томилолт, зочны зардал	12,290,000.00	15,885,000.00
210702	Дотоод албан томилолт	10,290,000.00	15,885,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	940,900.00	813,597,868.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	813,597,868.80
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	640,900.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,179,614.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,179,614.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	223,393,450.30	37,360,625.88
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	37,360,625.88
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	37,360,625.88
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	37,360,625.88
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	37,360,625.88
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	223,393,450.30	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	223,393,450.30	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	54,666,000.00	(813,597,868.80)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	54,666,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	54,666,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	54,666,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	54,666,000.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(54,666,000.00)	-
14	Бусад эх үүсвэр	-	813,597,868.80
1451	Засгийн газрын гадаад төслийн зээл шинээр авах	-	813,597,868.80
145102	Бусад засгийн газрын гадаад төслийн зээл шинээр авах	-	813,597,868.80
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	813,597,868.80
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	57,694,102.55	57,694,102.55
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	57,694,102.55	57,694,102.55
9	Тайлант үеийн үр дүн	31,298,222.34	31,298,222.34
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	88,992,324.89	88,992,324.89
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	88,992,324.89	88,992,324.89
19	Тайлант үеийн үр дүн	(44,335,012.25)	(44,335,012.25)
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	44,657,312.64	44,657,312.64

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	892,299,200.00	765,456,674.12	(126,842,525.88)	85.8
12	Татварын бус орлого	892,299,200.00	765,456,674.12	(126,842,525.88)	85.8
122	Тусламжийн орлого	892,299,200.00	765,456,674.12	(126,842,525.88)	85.8
122005	Төсвөөс санхүүжих	892,299,200.00	765,456,674.12	(126,842,525.88)	85.8
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	892,299,200.00	765,456,674.12	(126,842,525.88)	85.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	892,299,200.00	765,456,674.12	(126,842,525.88)	85.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	892,299,200.00	765,456,674.12	(126,842,525.88)	85.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	618,360,000.00	594,734,912.52	(23,625,087.48)	96.2
210101	Үндсэн цалин	618,360,000.00	594,734,912.52	(23,625,087.48)	96.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,295,000.00	73,793,641.76	(3,501,358.24)	95.5
210201	Тэтгэврийн даатгал	52,560,600.00	50,178,778.64	(2,381,821.36)	95.5
210202	Тэтгэмжийн даатгал	6,183,600.00	5,903,490.78	(280,109.22)	95.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,091,800.00	2,951,895.39	(139,904.61)	95.5
210204	Ажилгүйдлийн даатгал	3,091,800.00	2,951,895.39	(139,904.61)	95.5
210205	Эрүүл мэндийн даатгал	12,367,200.00	11,807,581.56	(559,618.44)	95.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,380,000.00	74,117,658.33	(8,262,341.67)	90.0
210304	Байрны түрээс	82,380,000.00	74,117,658.33	(8,262,341.67)	90.0
2104	Хангамж, бараа материалын зардал	20,960,000.00	5,745,847.51	(15,214,152.49)	27.4
210401	Бичиг хэрэг	9,760,000.00	3,138,000.00	(6,622,000.00)	32.2
210402	Тээвэр, шатахуун	7,000,000.00	500,000.00	(6,500,000.00)	7.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,200,000.00	2,107,847.51	(92,152.49)	95.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	-	(2,000,000.00)	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,800,000.00	-	(29,800,000.00)	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,300,000.00	-	(12,300,000.00)	-
210602	Тавилга	7,500,000.00	-	(7,500,000.00)	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	10,000,000.00	-	(10,000,000.00)	-
2107	Томилолт, зочны зардал	35,680,000.00	15,885,000.00	(19,795,000.00)	44.5
210702	Дотоод албан томилолт	30,680,000.00	15,885,000.00	(14,795,000.00)	51.8
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,000,000.00	-	(5,000,000.00)	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,824,200.00	-	(25,824,200.00)	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,043,200.00	-	(17,043,200.00)	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,000,000.00	-	(8,000,000.00)	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	781,000.00	-	(781,000.00)	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	1,179,614.00	(820,386.00)	59.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	1,179,614.00	(820,386.00)	59.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-	-	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төвийн бүсийн цахилгаан эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэглээг хангах, Сайншанд дахь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдээс үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг төвийн болон өмнөд бүсийн сүлжээнд нийлүүлэх Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний төсөл хариуцсан нэгж юм.

Эрхэм зорилгоо “Төвийн бүсийн цахилгаан эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэглээг хангах, Сайншанд дахь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдээс үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг төвийн болон өмнөд бүсийн сүлжээнд нийлүүлэх” гэж тодорхойлсон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус Чойр-Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт 220.4 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35 кВ-ын дэд станц барих төсөл, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжид нийцүүлэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дах хэсэгт 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орсон;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 5 дугаар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” албан даалгавар;

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Чойр-Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт 220.4 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35 кВ-ын дэд станц барих төслийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тайлант онд Сангийн яамны салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Чойр-Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт 220.4 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35 кВ-ын дэд станц барих төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журмыг мөрдөн ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад тохироогүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Чойр-Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт 220.4 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35 кВ-ын дэд станц барих төсөл нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 45,813.5 мянган төгрөгөөр буюу 49.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Авлага	11,730.6	-	(11,730.6)
Бараа материал	2,950.0	800.0	(2,150.0)
Үндсэн хөрөнгө	78,697.5	46,764.6	(31,932.9)
Нийт хөрөнгө	93,378.1	47,564.6	(45,813.5)
Богино хугацаат өр төлбөр	4,385.8	2,907.3	(1,478.5)
Засгийн газрын хувь оролцоо	88,992.3	44,657.3	(44,335.0)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	93,378.1	47,564.6	(45,813.5)

Дээрх хүснэгтээс харахад авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

- Авлагын дансны үлдэгдэл 11,730.6 мянган төгрөгөөр буурсан нь 10,805.6 мянган төгрөгийн томилолтын авлага, 925.0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг барагдуулснаас шалтгаалсан.
- Бараа материалын дансны үлдэгдэл 2,150.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 2,150.0 мянган төгрөгийн бараа материалыг албан хэрэгцээнд зарцуулснаас шалтгаалсан.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 31,932.9 мянган төгрөгөөр буурсан нь 31,932.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулснаас шалтгаалсан.
- Өр төлбөрийн дансны үлдэгдэл 1,478.5 мянган төгрөгөөр буурсан нь 4,385.8 мянган төгрөгийн ажилчдад өгөх өр төлбөрийг барагдуулж, 2,907.3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүссэн байна.
- Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ дансны үлдэгдэл 44,335.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн буурснаас шалтгаалсан.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус Чойр-Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт 220.4 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35 кВ-ын дэд станц барих төслийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 925,283.5 мянган төгрөг, гадаадын зээлээс 3,494,353.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн хангамж, бараа материалын зардлыг 21,527.5 мянган төгрөг, албан томилолтын зардлыг 1,000.0 мянган төгрөг, нийт 32,984.3 мянган төгрөгөөр бууруулж, 892,299.2 мянган төгрөгийг хянан баталсан байна.

Энэ нь 2025 төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 802,817.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, 765,456.7 мянган төгрөгийг зарцуулж, дутуу зарцуулсан 37,360.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Гадаадын зээлээс 813,597.9 мянган төгрөгийг Сангийн ямаар дамжуулж зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч байгууллага руу шилжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 765,456.7 мянган төгрөг буюу 85.8 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 23,625.1 мянган төгрөг, НДШ-ийн зардал 3,501.4 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал, 8,262.3 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 15,214.2 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 29,800.0 мянган төгрөг, томилолт зочны зардал 19,795.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 25,824.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 820.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2.Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

					/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	70207-83112 гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	892,299.2	765,456.7	(126,842.5)	85.8	
Нийт		892,299.2	765,456.7	(126,842.5)	85.8	

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Тухайлбал:

- Төсөл хариуцагч нэгжийн орон тооны дээд хязгаарыг удирдах 1, гүйцэтгэх 9, нийт 10 орон тоо баталж, гүйцэтгэлээр удирдах 1, гүйцэтгэх 9, нийт 10 орон тоотой ажилласан байна.
- Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн 1,628.0 мянган төгрөгийн Акалоус санхүүгийн программ ашиглаж байна.
- Тайланд хугацаанд гадаад томилолт, гадаад зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг төлөвлөөгүй, гүйцэтгэлээр санхүүжүүлээгүй байна.
- Хурал, зөвлөгөөн түүнтэй адилтгах арга хэмжээний зардлыг төлөвлөөгүй, гүйцэтгэлээр санхүүжүүлээгүй байна.
- Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн мэдээллийн зардал гараагүй байна.
- Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.2.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төслийн хүрэх үр дүн:

Чойр-Сайншанд чиглэлийн 230 км 220 кВ-ын 2 хэлхээт өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35/6 кВ-ын Чойр дэд станцын 220 кВ-ын талын өргөтгөл, 220/110/35 кВ-ын Сайншанд дэд станц барина.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төслийн 3 худалдан авах ажиллагаанаас зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулагдсан бол захиалагчийн хяналт хийх, барилга угсралтын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажлууд хийгдэж байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Чойр-Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт 220.4 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35 кВ-ын дэд станц барих төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Чойр-Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт 220.4 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35 кВ-ын дэд станц барих төсөл төсөл, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах үндсэн хөрөнгийн үнэ цэн, цахим баримттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор О.Эрдэнэчимэг, Ш.Солонго нар гүйцэтгэж, чанарын хяналтын мэргэжилтэн С.Сождмаа, захирал С.Тунгалаг нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор П.Амарсанаа, аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Чойр-Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт 220.4 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35 кВ-ын дэд станц барих төсөл 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дүгээр сарын 22-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “ИХ” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 12,006,292.8 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 60,031.5 мянган төгрөгөөр тогтоож санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөгөө хөтөлбөрийг батлуулсан. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан хуулиар хориглосон хязгаарласан арга хэмжээг тайлант онд санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн шилэн данстай холбоотой 1 зөрчилд зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд 155 мэдээлэл байршуулахаас 1,449,975.0 мянган төгрөгийн 11 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна", 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.8-д "Энэ хуулийн 3.1.3-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд, тогтмол мэдээлэх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Худалдан авах ажиллагааны талаар дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 856,699.3 мянган төгрөгийн 6 алдаа¹ илэрснээс аудитын явцад 856,699.3 мянган төгрөгийн 6 алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

- Шалгагдагч байгууллага нь тайлант оны төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын А/3 дугаар тушаалын 8 дугаар хавсралтын Маягт ТГТ-2 маягтын дагуу иж бүрэн тайлагнаагүй.
- Засгийн газрын гадаад төслийн зээлийн төрийн сан дахь 101900011818 тоот харилцах дансны 813,597.8 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг нягтлан бодох бүртгэл бүртгэж тайлагнаагүй.
- Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардлын харилцах дансны тайлант оны үлдэгдлийг 1,500.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.
- Тайлант оны нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг 1,630.2 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг тайланг бэлтгээгүй, тохируулыг хийгээгүйгээс төсвийн гүйцэтгэлийн тайлан 37,360.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан.
- Нийт 2,150.0 мянган төгрөгийн бараа материалын зарцуулалтыг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнаагүйг залруулсан.

Аудитаар нийт 222,654,906.6 мянган төгрөгийн 2 зөрчил² илэрсэнд зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 222,654,906.6 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 222,594,875.1 мянган төгрөгөөс их тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төслийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

Төслийг хэрэгжүүлэхээр Европын сэргээн болголт, хөгжлийн банктай 2019 оны 04 сарын 09-ны өдөр байгуулсан 62,800.0 мянган ам долларын зээлийн хэлэлцээрт, уг төслийг 2026 оны 12 сарын 31-ны өдөр дуусгахаар төлөвлөсөн боловч тайлант онд 960.0 мянган ам долларын зөвлөх үйлчилгээний гэрээний урьдчилгаа төлбөрт 227.5 мянган ам доллар буюу 813,597.9 мянган төгрөгийг шилжүүлж, барилга угсралтын ажил хийгдэж эхлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Сангийн сайдын 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалын хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.1.2-т "Төсөл, арга хэмжээг тогтоосон хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлэх" 4.1.3-т "Санхүү, төсвийн зохистой, үр ашигтай удирдлагыг хэрэгжүүлэх", 4.1.5-д "Үйл ажиллагааны шуурхай, хариуцлагатай, тогтвортой байдлыг хангах." гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төслийн үндсэн ажлыг яаралтай хэрэгжүүлж гэрээнд заасан хугацаанд дуусгаж ажиллах.

2. Гэрээтэй холбоотой асуудал

Зээллэгийн хөрөнгийг бүрэн ашиглаагүйгээс дамжуулан зээлдүүлэх гэрээний нөхцөлийн дагуу 2 дугаар эх үүсвэрээс 31.0 мянган ам доллар буюу 110,256.5 мянган төгрөгийн хураамж төлж үргүй зардал гаргах эрсдэлтэй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалын хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.1.2-т "Төсөл, арга хэмжээг тогтоосон хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлэх", 4.1.3-т "Санхүү, төсвийн зохистой, үр ашигтай удирдлагыг хэрэгжүүлэх", 4.1.5-д "Үйл ажиллагааны шуурхай, хариуцлагатай, тогтвортой байдлыг хангах", Зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 139/г-36/2023/203/205 дугаар гэрээний гэрээний 1.1.4-д "Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж нь жилийн 0.5 хувь байх ба зээлийн гэрээ байгуулагдсан өдрөөс эхлэн тухайн ашиглаж буй эх үүсвэрээр тооцно. Нэгдүгээр эх үүсвэр ашиглагдаж дууссанаар хоёрдугаар эх үүсвэрийн ашиглаагүй үлдэгдлээс тооцно" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төслийн ажлын хугацаанд нь дуусгах, нэмэлт үргүй зардал гаргахгүй байх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Шалгагдагч байгууллага нь тайлант оны төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын А/З дугаар тушаалын 8 дугаар хавсралтын Маягт ТГТ-2 маягтын дагуу иж бүрэн тайлагнаагүй байна.	1	-	1	-			1	-	-	-	-	-
2	Засгийн газрын гадаад төслийн зээлийн төрийн сан дахь 101900011818 тоот харилцах дансны 813,597.8 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг нягтлан бодох бүртгэл бүртгэж тайлагнаагүй байна.	1	813,597.9	1	813,597.9			1	813,597.9				
3	Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардлын харилцах дансны тайлант оны үлдэгдлийг 1,500.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна	1	1,500.0			1	1,500.0	1	1,500.0				
4	Тайлант оны нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг 1,630.2 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.	1	1,630.2			1	1,630.2	1	1,630.2				
5	Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг тайланг бэлтгээгүй, тохируулыг хийгээгүйгээс төсвийн гүйцэтгэлийн тайлан 37,360.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан байна.	1	37,360.6			1	37,360.6	1	37,360.6				
6	Нийт 2,150.0 мянган төгрөгийн бараа материалын зарцуулалтыг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнаагүй байна.	1	2,150.0	1	2,150.0			1	2,150.0				
	Дүн	6	856,238.7	6	815,747.9	6	40,490.9	6	856,238.7	-	-	-	-

Чойр-Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт 220.4 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35 кВ-ын дэд станц барих төсөл
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Төслийг хэрэгжүүлэхээр Европын сэргээн болголт, хөгжлийн банкттай 2019 оны 04 сарын 09-ны өдөр байгуулсан 62,800.0 мянган ам долларын зээлийн хэлэлцээрт, уг төслийг 2026 оны 12 сарын 31-ны өдөр дуусгахаар төлөвлөсөн боловч тайлант онд 960.0 мянган ам долларын зөвлөх үйлчилгээний гэрээний урьдчилгаа төлбөрт 227.5 мянган ам доллар буюу 813,597.9 мянган төгрөгийг шилжүүлж, барилга угсралтын ажил хийгдэж эхлээгүй байна.	1	222,544,650.1	-	-	-	-	1	222,544,650.1	-	-	-	-
2	Зээллэгийн хөрөнгийг бүрэн ашиглаагүйгээс дамжуулан зээлдүүлэх гэрээний нөхцөлийн дагуу 2 дугаар эх үүсвэрээс 31.0 мянган ам доллар буюу 110,256.5 мянган төгрөгийн хураамж төлж үргүй зардал гаргах эрсдэлтэй байна.	1	110,256.5	-	-	-	-	1	110,256.5	-	-	-	-
Дүн		2	222,654,906.6	-	-	-	-	2	222,654,906.6	-	-	-	-

Чойр-Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт 220.4 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам, 220/110/35 кВ-ын дэд станц барих төсөл
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
1	Шилэн дансны цахим мэдээлэлд нийт 155 мэдээлэл байршуулахаас 1,449,975.0 мянган төгрөгийн 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	-	-	-	1	1,449,975.0
Дүн		1	-	-	-	1	1,449,975.0